

**“СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ”,
“СОГТУУРУУЛАХ УНДААГААР ҮЙЛЧЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ”-ИЙГ**

тухайн нутаг дэвсгэрт оршин сууж байгаа хүн амын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээ, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал, эрүүл мэнд, соёл, спортын байгууллага, оюутан, сурагчдын хичээлийн болон дотуур байрны байршил, аймаг, нийслэлийн саналыг харгалзан хүнс, эрүүл мэнд болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд хамтран тогтоосон тоонд нийцүүлэн аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсэд чөлөөт бүсийн захирагч

**“СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ, АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ
ТУХАЙ ХУУЛЬ”, “ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ”-Д ЗААСНААР АШГИЙН ТӨЛӨӨ ХУУЛИЙН
ЭТГЭЭДЭД олгож, сунгаж, түдгэлзүүлж, сэргээж, хүчингүй болгоно.**

- .Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг таван жилийн хугацаагаар олгож, мөн хугацаагаар тухай бүр сунгаж болох бөгөөд таван жилээс дээш хугацаагаар сунгахгүй
- Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч техникийн зохицуулалт, стандартын шаардлага хангасан, чанар, аюулгүй байдлыг баталгаажуулсан, тохирлын гэрчилгээ авсан согтууруулах ундааг худалдана.
- Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уг зөвшөөрлийг бэлэглэх, худалдах, барьцаалах, түрээслэх зэргээр бусдад шилжүүлэх болон энэ хуульд зааснаас бусад тохиолдолд үйл ажиллагаа явуулах байршлыг өөрчлөхийг хориглоно.
- Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, цахим төлбөрийн баримтын системд холбогдсон, татварын байгууллагад хугацаа хэтэрсэн өргүй этгээдэд олгоно.
- Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй холбогдсон энэ хуулиар зохицуулаагүй бусад харилцааг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.
- Тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд шийдвэр гарснаас хойш ажлын хоёр өдрийн дотор үндэслэлийг тодорхой дурдсан мэдэгдлийг тухайн хуулийн этгээдэд хүргүүлнэ.

**СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ,
СОГТУУРУУЛАХ УНДААГААР ҮЙЛЧЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН
АШГИЙН ТӨЛӨӨ ХУУЛИЙН ЭТГЭЭД ДАРААХ БАРИМТ БИЧГИЙГ БҮРДҮҮЛНЭ:**

- Аймгийн ЗДТГ-ын БОНХОБТХ–ийн дарга танаа гэж толгой хийж согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл хүссэн компани, хоршооны тамга, гарын үсэг зурж баталгаажуулсан албан бичиг(*худалдаа, үйлчилгээний төрөл, худалдаа үйлчилгээний газрын оноосон нэр, байрлах хаяг, харилцах утсыг тодорхой дурдах*);
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- Сумын Засаг даргын дэмжсэн бичиг
- Цагдаагийн байгууллагын телекамерын (MNS6423:2019 стандарт) тодорхойлолтыг аймгийн ЦГ-ын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлын тасаг тодорхойлолт албан бичиг. (*Сууриллуулсан телекамерын бодит зураг нотломж болон аж ахуйн нэгжийн телекамер тодорхойлолт авах хүсэлт бүхий албан бичиг*)
- Хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагаас тухайн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагааг эрхлэх талаар гаргасан улсын байцаагчийн болон ажлын байрны дүгнэлт(ТОХИРЛЫН ГЭРЧИЛГЭЭНИЙ хуулбар)
- Тухайн үйл ажиллагааг эрхлэх байранд хийгдсэн онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын ГАЛЫН ДҮГНЭЛТИЙН хуулбар



МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ MNS 6423:2019



/ТЕЛЕ ХЯНАЛТЫН СИСТЕМИЙН ТЕХНИКИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА/

Дүрс бичлэгийн төхөөрөмжийн техникийн шаардлага:

6.2.1 Теле хяналтын камерын системийн дүрс бичлэгийг 720 цагаас багагүй хугацаанд хадгална.

6.2.2 Дүрс бичлэгийн төхөөрөмж нь бүх сувагтаа 6 мегапиксель /3072x2048/ 25 фрейм/секунд дээш чанартай дүрс бичлэг хийх чадамжтай.

6.2.3 Дүрс бичлэгийг AVI, MP4 өргөтгөлөөр хуулбарладаг байна.

Теле хяналтын камерт тавих шаардлага

8.1.5 Теле хяналтын камерын хяналтын цэгийн тоног төхөөрөмж нь цахилгааны хүчдэл тогтворжуулж, системийн тасралтгүй ажиллагааг хангах үл тасалдах тэжээлийн төхөөрөмж (UPS)-тэй байна. /1 цагаас дээш хугацаанд цахилгаан тэжээлээр хангах боломжтой байна/

8.2.2 Теле хяналтын камерыг хяналт тавих зорилгоос хамааруулан 2 ангилна.

- Ажиглалтын зорилгоор ашиглах теле хяналтын камер
- Хяналтын зорилгоор ашиглах теле хяналтын камер

8.2.6 Теле хяналтын камерын дүрсний нягтрал нь дор дурдсан техникийн үзүүлэлтээс багагүй байна.

Камерын төрөл	Ажиглалтын	Хяналтын	Барилга, байгууламжийн гадна хяналтын
Хөдөлгөөнт	4 мегапиксель /2560x1600/, 25 фрейм секунд дүрс, 36 дахин татах	4 мегапиксель /2560x1600/, 25 фрейм секунд дүрс, 25 дахин татах	4 мегапиксель /2560x1600/, 25 фрейм секунд дүрс, 16 дахин татах
Чиглэлийн	8 мегапиксель /2560x1600/, 25 фрейм секунд дүрс	4 мегапиксель /2560x1600/, 25 фрейм секунд дүрс	

8.2.7 Байгалийн гэрлийн орчинд тохирч ажиллах өдөр, шөнийн автомат функцтэй байна.

8.2.9 Дүрс хувиргаж дамжуулах шахалтын горим нь h.265 болон түүний дараагийн үеийн технологи байна.

11 Засвар үйлчилгээ

11.1 Харууцагч, ашиглагч байгууллага, хувь хүн теле хяналтын камерын хэвийн, тасралтгүй үйл ажиллагааг хангах, үйлчилгээ хийх ажлыг зохион байгуулна.

11.2 Бүх тоног төхөөрөмжид жилд 2-оос доошгүй удаа техникийн үзлэг, үйлчилгээ, цэвэрлэгээ хийнэ. Энэ нь байнгын үйл ажиллагааны засварт хамаарна

11.3 Эвдрэлийн түвшин, хариу арга хэмжээ авах хугацаа зэргээс хамааран засвар үйлчилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.

MNS 6423 : 2019 Хяналтын камер стандарт

Теле хяналтын системийн техникийн ерөнхий шаардлага Хамрах хүрээ